



**“Ойд үйлдвэрлэлийн ашиглалт” ба “Ойн арчилгаа цэвэрлэгээний үйл ажиллагаа эрхэлдэг ААН, байгууллагын үйл ажиллагаанд магадлан итгэмжлэл хийх шалгуур үзүүлэлтийг дүгнэх аргачлал**

**Нэг. Ерөнхий зүйл**

1.1.Энэхүү арга зүйг “Ойд үйлдвэрлэлийн ашиглалт” ба “Ойн арчилгаа цэвэрлэгээний үйл ажиллагаа эрхэлдэг ААН, байгууллагын үйл ажиллагаанд магадлан итгэмжлэл явуулахад мөрдлөг болгон ажиллана.

1.2. “Ойд үйлдвэрлэлийн ашиглалт” ба “Ойн арчилгаа цэвэрлэгээний үйл ажиллагаа эрхэлдэг ААН, байгууллагын үйл ажиллагаанд хийх магадлан итгэмжлэлийг ойн ашиглалт, арчилгаа, цэвэрлэгээний чиглэлээр мэргэшсэн 3-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй шинжээчдийн баг гүйцэтгэнэ.

1.3.Магадлан итгэмжлэлийг аж ахуйн нэгж байгууллагууд сайн дурын үндсэн дээр, харилцан тохиролцож, тодорхой төсөвт өртөгт багтаан, гэрээний үндсэн дээр хийнэ.

**Хоёр. Магадлан итгэмжлэлийн шинжээчийн ёс зүйн нийтлэг зарчим**

2.1. Багийн гишүүд нь шинжээчдийн ёс зүйг чанд сахин, хараат бус, шударга, мэргэжлийн ур чадвар, туршлагад тулгуурлан асуудлыг бодитойгоор баталгаа, баримтад үндэслэн үнэлж, дүгнэнэ.

2.2. Олон улсын стандартад заасан арга хэлбэрээр үйл ажиллагаа явуулах

2.3. Хараат бус байх

2.4. Харилцагчийн мэдээллийн нууцыг хадгалах

2.5. Шударга өрсөлдөөний зарчмыг мөрдөх

2.6. Шинжээчийн үйл ажиллагааг явуулахдаа мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандах

2.7.Үнэлэлт дүгнэлтийг баримтаар нотлон баталгаажуулах



2.8.Багийн ахлагч ахлах шинжээч байж, аливаа маргааныг таслан шийдвэрлэнэ.

### **Гурав. Магадлан итгэмжлэл хийх шалгуур үзүүлэлтүүд түүнд үнэлгээ өгөх**

3.1.Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд магадлан итгэмжлэл хийх хавсралтаар өгөгдсөн шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар үнэлж, дүгнэнэ. Үүнд:

#### **3.1.Хүний нөөцийн чиглэлээр:**

1.1. Захирлын боловсрол: дээд мэргэжлийн дипломтой бол 1гэсэн оноо байхгүй бол 0 оноо өгнө. Мэргэжил харгалзахгүй. Диплом доод тал нь 4 жил суралцсан тухайн мэргэжлээр баклаварын түвшин хангасан байна.

1.2.Ажилчид албан хаагчдын боловсрол: Мод бэлтгэлийн үйл ажиллагааг талбайд хариуцан ажиллах нэгжийн дарга нь ойн дээд боловсролтой бол 6, ойн техникч мэргэжилтэй бол 4 оноо өгнө. Өөр мэргэжлийн хүн байвал эсвэл хариуцсан хүн байхгүй бол 0 оноо өгнө.

1.3.Мод бэлтгэгч нарын мэргэжлийн боловсрол: мод бэлтгэлийн бригадын тракторчин, туушаар тээвэрлэх тохиолдолд ачигч нь тусгай мэргэжлийн үнэмлэхтэй /ТМС, МҮСТ төгссөн/ бол тус бүрт нь 2 оноо, байхгүй бол 0 оноо өгнө.

1.3а.Мод бэлтгэлийн хөрөөчин, оосорлогч, мөчирлөгч, мод саалагч, талбай цэвэрлэгч, ачигч /техникээр биш тохиолдолд/ мэргэжлийн үнэмлэхтэй бол тус бүрт нь 1оноо байхгүй бол 0 оноо өгнө. Мэргэжлийн үнэмлэх гэдэгт багадаа 2 долоо хоногийн курс төгссөн байх.

**1**.4.Мод бэлтгэлийн байнгын бригадтай бол 4 оноо, байхгүй бол 0 оноо өгнө. Мод бэлтгэлийн байнгын бригад нь тракторчин, хөрөөчин, оосорлогч, тогооч, ачигч, мод тээврийн машины жолоочоос бүрдэнэ. Бригад багадаа **6** хүнтэй байна. Байнгын ажилагаатай эсэхийг ажилчдын НДД-т хийсэн ажилд авсан тухай тушаалын бичилт , нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг харгалзан үзнэ. Тухайн ажилчин жилийн ядаж 4 сард нь цалин авч тогтвортой ажилладаг байх шаардлагыг хангах.



1.5. Ажилчдын давтан сургалт: ажилчид жилд 3-аас доошгүй өдөр давтан сургалтанд хамрагдсан бол 2 оноо, хамрагдаагүй бол 0 оноо өгөх. Сургалт явуулах тухай, эсвэл сургалтанд хамруулах тухай захирлын тушаал, сургалт явуулсан хүнд олгосон цалин хөлс, сургалтанд заасан хичээлийн программ, үзүүлэн, лекц, бичлэг зэргийг баримтлан дүгнэх. Хэрвээ тухайн байгууллага олон хүнтэй бол нийт ажилчдын 40-с доошгүй хувь сургалтанд хамрагдсан байж болно.

### 3.2. Хөдөлмөрийн аюулгүй байдлын баримт бичгүүд:

2.1. Ажилчид ХАБ-ын зааварчилгааг өдөр тутам авч гарын үсгээр баталгаажуулдаг бол 4 оноо үгүй бол 0 оноо. Өдөр тутмын ХАБ-ын зааварчилгаа ажлын талбайд/ажлын байранд/ хариуцсан хүнд байгаа эсэхийг шалгана. Байхгүй бол энэ асуудалд шууд 0 оноо өгнө. Хэрвээ байвал гарын үсэг зуруулдаг дэвтрийн **сүүлийн нэг сараас доошгүй** ажлын хоногийн гарын үсэг зурсан байдлыг шалгана. Ажлын нэг л өдөр гарын үсэг дутуу зуруулсан бол энэ ажлыг 0 гэж дүгнэнэ.

2.2. Тухайн аж ахуйн нэр дээр бүртгэлтэй мод бэлтгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа өөрөө явагч машин, механизм тухайн жилийн улсын үзлэгт хамрагдсан бол тус бүрт нь **1** оноо, хамрагдаагүй машин, механизм бүрт 0 оноо өгнө.

2.3. Тухайн аж ахуйн нэр дээр бүртгэлтэй мод бэлтгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа тоног төхөөрөмжүүд ХАБ-ын шаардлага хангасан гэрчилгээтэй бол тус **бүрт 1 оноо**, байхгүй тоног төхөөрөмж бүрт 0 оноо өгнө.

2.4. Бүх тоног төхөөрөмжүүд аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ашиглалтын заавартай бол төхөөрөмж **бүрт 2** оноо байхгүй төхөөрөмж бүрт 0 оноо өгнө.

2.5. ХАБ-ын бодлого, журам, хөтөлбөрийг захирлын тушаалаар баталж, албажуулан ашигладаг, постер байрлуулсан бол бол 4 оноо үгүй бол 0 оноо өгнө.

2.6. Бүх ажилчид анхны тусламж үзүүлэх сургалтанд жил бүр бүрэн хамрагдсан бол 4 оноо, нийт ажилчдын 3/4 хамрагдсан бол 3 оноо, 1/2 хамрагдсан 2 оноо, 1/4 хамрагдсан бол 1 оноо хамрагдаагүй бол 0 оноо өгнө.

2.7. Мод бэлтгэлийн талбайд онцгой байдлын үед ашиглах дохиолол, холбоо, байнгын автомашин байдаг бол 2 оноо байхгүй бол 0 оноо өгнө. Мод



бэлтгэлийн ажил явагдаж байгаа талбайд сүлжээ барих боломжтой бол ХАБ-ын асуудал хариуцсан хүний гар утасны бэлэн байдлыг шалган /ажиллаж байгаа эсэх, цэнэг барилт, нэгж байгаа эсэх г.м/ дүгнэлт оноо өгөх. Хэрэв сүлжээ барихгүй газарт ажил гүйцэтгэж байгаа бол байнгын автомашин ажиллаж байгааг харгалзан үнэлгээ өгөх.

### 3.3 Тоног төхөөрөмжийн аюулгүй байдал:

3.1.Мод унагах хөрөө аюулгүй ажиллагааны шаардлага хангасан бол 2 оноо, хангаагүй гэж үзвэл 0 оноо өгнө. Шаардлага хангасан мод унагах хөрөө гэдэгт цеп, доргионы хамгаалалттай хөрөө ашиглахыг хэлнэ. /Иж бүрэн тоноглол бүхий Урал-5, евро стандартын хөрөө орно./

3.2.Хөрөөчин зориулалтын ажлын хувцас, дуулга, хамгаалалтын гутал бээлийтэй бол 6 оноо өгнө. Хөрөөчин зориулалтын өмд /асаалттай хөрөөний ир хүрсэн тохиолдолд эргэлтийг зогсоодог/ өмссөн бол 2 оноо, дуулга өмсдөг бол 1 оноо, бээлийтэй бол-1 оноо, зориулалтын гутал /гутлын хоншоор хэсэг төмөр хамгаалалттай/ өмсдөг бол 2 оноог тус тус өгнө.

3.3.Мод бэлтгэлийн талбайд ажиллагсад ажлын хувцас, дуулга, хамгаалалтын гутал бээлийтэй бол 4 оноо өгнө. /гутал 2 оноо, бээлий 1 оноо, дуулга 1 оноо тус тус өгнө/

3.4а.Мод цагаалгын ажилд зориулалтын аюулгүй байдлыг хангасан тоног төхөөрөмж ашиглаж байгаа бол 2 оноо үгүй бол 0 оноо өгнө. /зориулалтын гэдэгт мод үүрэх шит, ган татлага бүхий цагаалгын тракторууд, ердийн хөсөг, хөдөө аж ахуйн зориулалттай трактор ашигладаг бол заавал булхайтай байхыг ойлгоно/

3.4б.Модыг туушаар тээвэрлэх тохиолдолд ачилтын ажилд зориулалтын аюулгүй байдлыг хангасан тоног төхөөрөмж ашиглаж байгаа бол 4 оноо үгүй бол 0 оноо өгнө. /зориулалтын гэдэгт мод төрөл бүрийн эрүүт ачигч, олон үйлдэлт тракторууд орно/.

3.4в.Бэлтгэсэн модыг 4-6 метрийн урттай гуалин хэлбэрээр, 2 хүртлэх урттай түлш хэлбэрээр тээвэрлэж байгаа тохиолдолд ачилтын ажилд аюулгүй байдлыг хангасан тоног төхөөрөмж ашиглаж байгаа бол 2 оноо үгүй бол 0 оноо өгнө./канадан төхөөрөмж, өргөгч техник, төхөөрөмж г.м хөдөлмөр хөнгөвчилсэн техник төхөөрөмжийг ойлгоно/.



3.5. Мод бэлтгэлийн талбайд иж бүрэн анхны тусламжийн эмийн сантай бол 2 оноо, үгүй бол 0 оноо өгнө. /доторх иж бүрдэл, ашиглалтын хугацааг харгалзана/

### **3.4. Галын аюулгүй байдлыг хангах чиглэлээр :**

4.1. Ойн түймрээс урьдчилан сэргийлэх зааварчилга, сэрэмжлүүлсэн самбарыг ажлын талбайд байрлуулсан бол 2 оноо үгүй бол 0 оноо өгнө.

4.2. Мод бэлтгэлийн талбайг цэвэрлэж түймрийн аюулгүй болгосон бол 1 оноо, үгүй бол 0 оноо өгнө. /Мод бэлтгэлийн талбайг цэвэрлэх гэдэгт үлдэгдэл гишүү мөчрийг овоолох, эсвэл талбайгаас гаргасан байх, 6 см-ээс доош бүдүүн мөчрийг цагаалгын болон тээврийн замд дэвссэн байхыг ойлгоно/

4.3. Ойн түймэртэй тэмцэх багаж хэрэгслийг ажлын талбайд байршуулсан бол 2 оноо, үгүй бол 0 оноо өгнө. /Багаж хэрэгсэлд галын хор, цохиур, хүрз, тармуур, гэх мэт/.

4.4. Мод бэлтгэлийн ажилчид жилд 1-ээс доошгүй ойн түймэртэй тэмцэх арга зүйн сургалтанд хамрагдсан байна. /сургалт явуулж байгаа фото зураг, сургалтын хөтөлбөр зэргийг харгалзан дүгнэх/

### **3.5. Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа, техник технологийн чиглэлээр:**

5.1. Хөрс хамгаалах зорилгоор зуны улиралд хөрс нягтрахаас сэргийлэн мод цагаалах ажилд гинжит трактор ашигладаг бол 2 оноо, үгүй бол 0 оноо өгнө. Мод бэлтгэлийн талбайг сонгон үзэж үнэлэлт өгнө. Фото зургаар баримтжуулна.

5.2. Хөрсөн дээр санамсаргүй байдлаар асгасан тосыг цэвэрлэх, аюулгүй болгох, саармагжуулах арга зүй, зааварчилгатай байх, бодис, саармагжуулагч бэлэн байлгах 3 оноо, үгүй бол 0 оноо өгнө. /асгарсан тосыг үртэсээр шингээж авч болно. дээрхи сонгон үзсэн талбайд шалгаж үзнэ фото зургаар баримтжуулна/

5.3. Ойд ахуйн хог хаягдалын нэгдсэн цэгтэй байх, түүнийг ажил дууссаны дараа цэвэрлэн нэгдсэн хогийн цэгт аваачсан бол 2 оноо үгүй бол 0 оноо өгнө./талбайг сонгон үзэж фото зургаар баримтжуулна/



5.4.Гадаргын усыг хамгаалах зорилгоор бохирдуулахгүй байх бичгэн зааварчилгаа, ундны ус авах цэгийг тогтоон хаяг зоох, хувцас цагаан хэрэгсэл угаах зориулалтын савтай бол 2 оноо, үгүй бол 0 оноо өгнө.

### **3.6.Модны ашиглалт:**

6.1.Үйлдвэрлэлийн ашиглалт болон арчилгаа цэвэрлэгээний ажлын явцад унагаж бэлтгэсэн болон байгалийн аясаар унасан модыг талбайгаас бүрэн гаргаж тээвэрлэсэн бол 6 оноо, тээвэрлэлт 80 хувиас дээш бол 4 оноо, 80 хувиас доош бол 0 оноо өгнө. /мод бэлтгэлийн ажил явагдаж бүрэн дууссан талбайгаас санамсаргүй байдлаар сонголт хийж газар дээр нь очиж үзээд дүгнэх/.

6.2.Унагасан болон цэвэрлэсэн модны хожуулын өндөр тухайн модны диаметрийн 1/3 –ээс багагүй байвал 2 оноо, өндөр бол 0 оноо өгнө. / байгалийн аясаар өөрөө унасан модны хожуул өндөр байгаа бол түүнийг тайрч дээр заасан хэмжээнд болгосон байна. Хожуулын өндрийг газрын дээд талаас хэмжинэ/.

6.3.Бөөрөнхий мод модон материалын стандартын хэрэгжилт ба мэдлэг сайн бол 2 оноо, хангалтгүй бол 0 оноо өгнө. /тухайн аж ахуйн нэгжийн доод склад дээр үзнэ. Гуалин, түлээний модны стандартыг шалгана/.

6.4.Бүтээгдэхүүний нэр төрөл дор хаяж 3-аас доошгүй нэр төрлийн мод модон бүтээгдэхүүн зах зээлд нийлүүлдэг бол 4 оноо цөөн бол 0 оноо өгнө. /бүх төрлийн зүсмэл материалын нэг нэр төрөлд тооцох ба гуалин, түлээ, ойн дагалт баялаг г.м орно/.

### **3.7.Үйл ажиллагааны үнэлгээ:**

7.1а.Мод бэлтгэх болон ой цэвэрлэх, арчилгааны огтлол хийх талаар эрх бүхий газартай байгуулсан гэрээтэй байх, гэрээ зөрчөөгүй бол 2 оноо, шаардлага хүлээн авч арилгасан бол 1 оноо өгнө. Гэрээ зөрчсөн, цуцлагдсан шаардлага биелүүлээгүй бол 0 оноо өгнө.

7.1б.Мод бэлтгэлийн технологийн картыг мөрдөн ажилладаг бол 2 оноо үгүй бол 0 оноо өгнө. /мод бэлтгэлийн технологийн картыг үзнэ. Технологийн картад заагдсан ажлыг зүйл нэг бүрээр нь дүгнэнэ. Нийт зүйл заалтын 80 хувь нь биелсэн бол технологийн картыг мөрдөн ажилладаг гэж үзэж оноо өгнө/.



### **3.8. Орон нутгийн үнэлгээ**

8.1.Тухайн аж ахуйн нэгж, байгууллага жилийн эцэст өмнөх оны ажлаа тухайн сум орон нутгийн ИТХ, Засаг дарга, ЗДТГ-ын аль нэгэнд дүгнүүлээд авсан үнэлгээ сайн бол 3 оноо, шаардлага хүлээн авч арилгасан бол 1 оноо өгнө. /Ажлыг дүгнэсэн хурлын материалтай танилцана. Хурлаар ажлаа дүгнүүлээгүй бол шалтгааныг тодруулна/.

### **3.9. Мод бэлтгэсэн талбайн ойжуулалт, ойн нөхөн сэргээлт:**

9.1.Тухайн жилийн мод бэлтгэлийн нийт ажлын хэмжээнд дүйцэх ойжуулалтын ажлыг бүрэн гүйцэтгэдэг бол 3 оноо, давуулан биелүүлдэг бол 4 оноо, дутуу хийсэн бол 1 оноо огт хийгээгүй бол 0 оноо өгнө. /ойжуулалтын ажлыг хүлээн авсан актыг үндэслэн дүгнэнэ, улс, орон нутгийн төсвөөр хийгдсэн ажил үүнд хамаарахгүй зөвхөн өөрийн хөрөнгөөр гүйцэтгэсэн ажил хамаарна. Ойжуулалтын ажлын зардлыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж, төлбөрийг шилжүүлсэн байж болно/

### **3.10. Ойн менежментийн төлөвлөгөө:**

10.1.Батлагдсан, хугацааны хувьд хүчин төгөлдөр ойн менежментийн төлөвлөгөөтэй байх, түүний хэрэгжилт сайн бол 3 оноо, хүчин төгөлдөр төлөвлөгөөгүй эсвэл хэрэгжилт хангалтгүй бол 0 оноо өгнө. /ОМТ хэрэгжилтийг үзүүлэлт нэг бүрээр үзэж дүгнэнэ. Тухайн жилийн төлөвлөгөө 80-с дээш хувь биелсэн бол 3 оноо өгнө, 60-80 хүртэл хувиар биелэсэн бол 2 оноо, 50-60хүртэл хувиар биелсэн бол 1 оноо өгнө. Тухайн аж ахуйн нэгж өөрийн эзэмшлийн ой байхгүй тохиолдолд Сумын болон Нөхөрлөлийн ОМТ-нд туссан ажлыг гүйцэтгэхэд оролцсон байдлаар, хамгийн сүүлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг шалгана/.

### **Дөрөв. Магадлан итгэмжлэлийг хангаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх**

4.1. Магадлан итгэмжлэлийн нийт шалгуур үзүүлэлтийн дагуу дүгнэж тайлан бичнэ.

4.2.Магадлан итгэмжлэлийг 3 жилд нэг удаа давтан явуулах ба тухайн ААН-ийн авсан оноо өмнөх үеийнхээс буурсан үзүүлэлттэй байвал магадлан итгэмжлэл олгохгүй.

\_\_\_оОо\_\_\_